



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 01 сарын 26 ны өдөр

Дугаар А/08

Эрхэмт

**Эрүүл мэндийн газрын дэргэд орон тооны бус сувилахуй,
эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний
албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Дүрэм чиг үүрэг батлах тухай" 495, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/136 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэд орон тооны бус "Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний алба"-ны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн байгууллагууд сувилахуйн алба, багийг томилон ажиллахыг байгууллагын дарга, захирал, холбоодын тэргүүн нарт үүрэг болгосугай.
3. Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний албаны төлөвлөгөөг хэрэгжүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн алба, багуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг албаны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
4. Албаны дарга, гишүүдийн урамшууллыг тухайн байгууллага өөрийн төсөвт багтаан сар бүр олгохыг байгууллагын дарга, захирал, холбоодын тэргүүн нарт зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн Эмнэлгийн тусламжийн чанар эрсдэл, магадлан итгэмжлэл хариуцсан ахлах мэргэжилтэн (П.Хишгээ) -д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/22 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ



Эрүүл мэндийн газрын 2023 оны 01 сарын 26 өдрийн 1/11 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

СУВИЛАХУЙ, ЭМНЭЛГИЙН ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Албаны дарга: Эрүүл мэндийн газрын Сувилахуй, Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

1. Бүсийн оношилгоо эмчилгээний төв Сувилахуйн албаны дарга-1
2. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нэгдсэн Сувилахуйн албаны дарга-1
3. Эрдэнэт-Медикал эмнэлэг Сувилахуйн албаны дарга-1
4. Эрдэнэт сувилал цогцолбор Сувилахуйн албаны дарга-1
5. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн Сувилахуйн албаны дарга-1
6. Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч-1
7. Өрхийн эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч -1
8. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн сэргээн засах эмчилгээний тасгийн ахлах сувилагч-1



Эрүүл мэндийн газрын 2023 оны 07 сарын 26 өдрийн 8/08 тоот тушаалын хоёрдугаар хэсэрт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭД СУВИЛАХУЙ, ЭМНЭЛГИЙН ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээний алба нь аймаг орон нутгийн хэмжээнд мэргэжлийн тусламж үйлчилгээний асуудлаар үнэлгээ дүгнэлт өгөхөд оролцох, бодлого зөвлөмжөөр хангах эрх бүхий орон тооны бус алба байна.
2. Алба нь тухайн эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн үзүүлж буй тусламж үйлчилгээг дэмжих, зөвлөн туслах, арга зүйгээр ханган ажиллана.
3. Орон нутгийн сувилахуй, эмнэлгийн тусгай мэргэжилтний нөөцийн бодлого, төлөвлөлт, тусламж үйлчилгээний чанарын талаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулж, сувилахуйн албадын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Хоёр. Албаны бүтэц, орон тоо

1. Албыг эрүүл мэндийн газрын даргын тушаалаар сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн болон шаардлагатай гэж үзсэн холбогдох мэргэжилтэнүүдийн төлөөлөлөөс ажлын туршлага, мэргэжлийн болон боловсролын зэрэг дэвийг харгалзан бүрдүүлнэ.
2. Албаны дарга нь эрүүл мэндийн газарт сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн байна.

Гурав. Албаны чиг үүрэг

1. Албаны үйл ажиллагаа нь улирал тутамд хуралдах бүх гишүүдийн хурал байна.
2. Хуралдаанаас протокол гарах бөгөөд бүх гишүүдийн 50-иас дээш хувь нь шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзсэн асуудлыг албаны дарга аймаг, орон нутгийн удирдлагад шийдвэрлүүлэхээр хүргүүлж болно.
3. Үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах
4. Эрүүл мэндийн байгууллагуудын сувилахуйн алба, багуудын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэж, дүгнэлтийг Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлд тайлагнах

Дөрөв. Хяналт үнэлгээ

1. Эрүүл мэндийн газар нь албаны үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр дүгнэнэ.
2. Эрүүл мэндийн газрын удирдлагын зөвлөлийн хурлаас албаны үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн бүрэлдэхүүнийг шинэчлэх болон шинээр томилох асуудлыг шийдэвэрлэж байна.
3. Албаны үйл ажиллагааны хагас бүтэн жилийн тайланг эрүүл мэндийн газрын даргын гарын үсгээр баталгаажуулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжид хүргүүлнэ.